

ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛ НАС БАРАЛТЫН ЭРГЭН МЭДЭЭЛЭЛ

2026 ОНЫ II ДУГААР УЛИРАЛ



Өвчлөл, ослын
тоон мэдээлэл



Нас баралтын
мэдээлэл



Эрсдэлт бүлэг,
шалтгаан



Урьдчилан сэргийлэлт,
зөвлөмж

Хянан тохиолдуулсан: ХШҮМХ-ийн дарга Я.Жаргал


Эмхэтгэсэн: Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтан М.Ганцэцэг



ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ 2026 оны II УЛИРАЛ

2026 оны хоёрдугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд гэмтэл хордлого, гадны шалтгаант 2177 шинэ тохиолдол бүртгэгдлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.4%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл хүйсээр




■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Нийт тохиолдлын 17.7% согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна.



Осол гэмтлийн шалтгаан өвчлөл, оноор, бодит тоогоор



Дээрх осол гэмтэлд өртсөн тохиолдлын 68% эрэгтэй, 32% эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 7 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй байна.



Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал хүйсээр


Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал	Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Согтууруулах ундаа хэрэглэсэн	350	23.6	36	5.2
Согтууруулах ундаа хэрэглээгүй	1131	76.4	660	94.8

Согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдлыг хүйсээр авч үзвэл эрэгтэчүүдийн 23.6% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осолд өтсөн байна.




ОСОЛ ГЭМТЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд шат, ор, сандал, цана, чарга, барилга байгууламжаас халтирч тээглэх гэх мэт бүх төрлийн уналтууд нэгдүгээр шалтгааныг эзэлж байгаа бол хоёрдугаарт бүх төрлийн тээврийн хэрэгсэл, явган зорчигч зам тээврийн осолд өртөх болон мориноос унаж гэмтсэн тохиолдлууд, 3 дугаарт санамсаргүй хорт бодист өртөх буюу спирт /архины хордлого/ болон бусад хий ууранд хордох тохиолдлууд эзэлж байна.



Осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг харьяаллаар авч үзвэл Арвайхээр, Тарагт, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Бүрд, Хархорин, Уянга сумдад хамгийн их буюу 10 000 хүн амд 153.7-253.7 тохиолдол ноогдож байна.


Осол гэмтлийн өвчлөл харьяаллаар 10 000 хүн амд



Осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 31.1 хувь нь 0-19 насны хүүхэд бол 68.9 хувь нь насанд хүрэгчид байлаа. Тохиолдлын тоо 30-49 насанд буюу эд хөдөлмөрийн насны залуучууд осол гэмтэлд хамгийн их өртсөн байна.




Осол гэмтлийн шалтгаант өвчлөл насны бүлгээр




Осол гэмтэлд өртөх үеийн байршлаар харвал хүмүүс гэртээ бэртэж гэмтэх тохиолдол хамгийн их буюу 57%-ийг эзэлж байна. Дараагаар нь гудамж, зам талбайд 22.5% хөдөө аж ахуй ферм 10%, биеийн тамир спортын талбай, сургууль цэцэрлэгт 6.5% гэмтэх тохиолдол түгээмэл байна.

Осол гарах үеийн байршил, хувиар




ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2026 ОНЫ I УЛИРАЛ

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар осол гэмтлийн шалтгаант 56 нас баралт бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Осол гэмтэл гадны шалтгаант нас баралтыг сараар нь авч үзвэл сүүлийн 3 жилийн дунджаар авч үзэхэд 2, 3, 5 дугаар саруудад хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна.




Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 63% (17) нь санамсаргүй үйлдэгдсэн осол гэмтэл эзэлж байгаа бол, 37% (10) хувь нь өөрийгөө болон бусдын амь насанд санаатайгаар гэмтэл учруулсан тохиолдол байна.




Нас баралт хүйс, оноор

2026 оны хоёрдугаар улирлын байдлаар нас барсан нийт тохиолдлын 92.9% нь эрэгтэйчүүд, 7.1% нь эмэгтэйчүүд байгаа ба осол гэмтлийн улмаас амь насаа алдаж буй 10 хүн тутмын 9 нь эрэгтэйчүүд байлаа.



Нас барах үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байдал хувиар




- Согтууруулах ундаа хэрэглэсэн
- Согтууруулах ундаа хэрэглээгүй

Осол гэмтлийн шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын **58.9 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж амь насаа алдсан байна.** Согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдлыг хүйсээр харвал 32 (96.9%) эрэгтэй байжээ.



Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтыг насны бүлэг тус бүрд харвал 45-49 насанд 17.9%, 25-29 насанд 12.5% хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 0-5 хүртэлх насны хүүхдийн нас баралт 3.6%-ийг эзэлж байна. Хамгийн бага нь 1 настай хүүхэд бол хамгийн өндөр нь 70 настай иргэн байна.



ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

Нас баралтын тэргүүлэх шалтгааны нэгдүгээрт санамсаргүй хорт бодист өртөх /архины хордлого, угаарын хийн хорлого/ тохиолдол 32.1%-ийг, хоёрдугаарт өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох тохиолдол 28.6%-ийг гуравдугаарт зам тээврийн ослын шалтгаант нас баралт 17.9%-ийг тус тус эзэлж байна.




Осол гэмтлийн шалтгааныг насны бүлгээр авч үзвэл 0-9 насанд зам тээврийн осол 75%, 20-29 насанд амиа хорлосон 66.7%, 30-39 насанд насанд амиа хорлосон 60% байгаа бол 50-59 насанд архины хордлогын шалтгаанаар нас барсан тохиолдол 60%-ийг эзэлж байна.

Хүснэгт 1. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт насны бүлэг, шалтгаанаар (N=56)

Осол гэмтлийн шалтгаан ICD-10 ангилалаар	0-9 N (%)	10-19 N (%)	20-29 N (%)	30-39 N (%)	40-49 N (%)	50-59 N (%)	60-с дээш N (%)
Зам тээврийн осол/V00-V99/	3 (75)		2 (22.2)		1 (6.6)	2 (20)	2 (18.2)
Бүх төрлийнуналт/W00-W19/					1 (6.6)		
Амьгүй механик хүчинд өртөх/W20-W49/					2 (13.3)		1 (9.1)
Амьд механик хүчинд өртөх/W50-W64/	1 (25)						
Усанд унаж живэх/W65-W74/		1 (50)					
Амьсгал боох аюултай бусад осол /W75-W84/							1 (9.1)
Байгалийн хүчинд өртөх /X30-X39/					2 (13.3)		
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх /X40-X49/			1 (11.1)		6 (40)	6 (60)	5 (45.5)
Түлэгдэлт /W85-X19/							
Амиа хорлох /X60-X84/		1 (50)	6 (66.7)	3 (60)	3 (20)	1 (10)	2 (18.2)
Хүчирхийлэл /X85-Y09/ бусдад хорлогдсон				2 (40)		1 (10)	
Нийт	4 (100)	2 (100)	9 (100)	5 (100)	15 (100)	10 (100)	11 (100)


Осол гэмтэл, гадны шалтгаант тэргүүлэх нас баралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад амиа хорлосон тохиолдол 45.4%, санамсаргүй хорт бодист өртсөн тохиолдол 2.2 дахин, зам тээврийн ослын тохиолдол 25%-иар тус тус өссөн байна.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан оноор




Санаатайгаар өөртөө гэмтэл учруулсан тохиолдлыг харьяаллаар авч үзвэл 10 000 хүн амд ноогдох түвшин Бат-Өлзий, Бүрд, Тарагт, Богд, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан сумдад аймгийн дунджаас өндөр байна.

Амиа хорлож нас барсан тохиолдол харьяаллаар 10 000 хүн амд



Санамсаргүй хорт бодист өртсөн тохиолдлыг харьяаллаар авч үзвэл Уянга, Өлзийт, Нарийнтгээл, Хайрхандулаан сумдад хамгийн олон тохиолдол бүртгэгдэж аймгийн дунджаас өндөр байна.

Санамсаргүй хорт бодист өртөж нас барсан тохиолдол 10 000 хүн амд



ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН МЭДЭЭНИЙ САНД САР БҮР ГАРЧ БУЙ НИЙТЛЭГ АЛДАА, ЗӨВЛӨМЖ

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь элбэг байдаг. Тиймээс 100-аас дээш настай хүмүүсийн бүртгэлээ үнэн эсэхийг нягтлах
2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, дээд боловсролтой болон аль нэг газар ажил эрхэлдэг гэсэн сонголт хийгдсэн байгаа эсэхийг шалгаж хэвших. Учир нь 5 настай хүүхдэд дээд боловсролтой, мөн 8 настай хүүхдэд ажил эрхэлдэг гэх мэт логикийн хувьд алдаатай бүртгэлүүд элбэг тохиолддог. Энэ нь хувь хүний мэдээллийн хэсгийг сайн шалгаагүйтэй холбоотой. Түүнчлэн хүүхэд байх үед нь бүртгэсэн мэдээллээ шинэчлээгүйтэй холбоотойгоор насанд хүрсэн хүмүүсийн албан тушаал 0-15 насны хүүхэд гэж бүртгэгдэж байна.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягталсны дараа бүртгэх, мэдээлэх
4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах
5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр явж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: V тэмдэглэгээний ард 1 гэсэн болон эхний асуултад унадаг дугуйг сонгоно гэсэн үг юм. Явган зорчигч бол V үсэгний ард 0 байна гэх мэт.
6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүн ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултанд хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсөгнөөс унасан буюу V80-р кодлох ба 2-р эгнээний асуултанд хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
8. Хүчирхийлэл буюу өвчний олон улсын ангиллаар дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар буруу кодолсон байна. Өвчний олон улсын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь



зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Жишээ нь: Тоглож байгаад санаандгүй нэгнээ түлхэж унагаад гэмтээсэн, сагс тоглож байгаад санаандгүй маажуулсан, гараа эргүүлж байсан хүнд санаандгүй цохигдох зэрэг нь W50 ангилалд орно. Харин санаатайгаар цохисон, маажсан, өшиглөсөн бол хүчирхийлэл гэсэн ангилалд оруулна. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!

9. Түүнчлэн хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь: Санаатайгаар боосон бол X91-р, хутгалсан бол X99-р, мод чулуугаар цохисон бол Y00-р, гар хөлөөрөө цохиж зодсон бол Y04-р кодлоно.

10. Түлэнхийн шалгаанаар /W85-X19/ тусламж авсан хүмүүст T20-T32-н хооронд онош тавих ёстой. Бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S тэй оношууд байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” багананд дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ.

11. “Тусгай тэмдэглэл” хэсэгт нэмэлт тайлбар шаардлагатай тохиолдлуудыг тэмдэглэх ба тухайн мөчид юу болсоныг тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлтээр бичнэ. Ингэснээр кодолж чадахгүй байгаа болон эргэлзээтэй тохиолдлуудаа тухай бүрт нь шийдвэрлэх ач холбогдолтой.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА

Жишээ нь: Гэр бүлээрээ болон олноороо явж байгаад зам тээврийн осолд орох, ажлын байр, гэр, байшин шатаж олон хүн түлэгдэх, байгалийн гамшиг тохиолдох, барилга байшин үйлдвэр уурхай нурах гэх мэтээс болж 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрт Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэст 80668103, 99668055 дугаарт мэдээлнэ үү! Та бүхний мэдээлж буй “Осол гэмтлийн шинэ тохиолдол” бүрийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн суурь болдогийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу!

